



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/53-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2025 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.21 № 36

танай _____-ны № _____-т

ӨНДӨР-УЛААН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.ВАНДАНДУЛАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, орон нутгийн нөөц хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, түүхийн хүрд баримтат кино бүтээх, гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа, улсын баяр наадам арга гэсэн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,235,423.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,185,742.7 мянган төгрөгийг зарцуулж, 49,680.6 мянган төгрөгийн хэмнэлт үүссэнийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 13 зорилт 152 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 118 арга хэмжээ нь дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 15 арга хэмжээ нь 80-90 хувь, 9 арга хэмжээ 70-80 хувь, 10 арга хэмжээ 70-аас доош хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 86.3 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,678,000.00	156,118,653.99
33	АВЛАГА	5,290,000.00	9,840,023.99
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	90,000.00	23.99
335	Бусад авлага	5,200,000.00	9,840,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,200,000.00	9,840,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	57,013,000.00	64,414,630.00
354	Хангамжийн материал	14,203,000.00	36,674,630.00
3541	Бичиг хэргийн материал		120,000.00
3542	Аж ахуйн материал	13,202,000.00	35,253,630.00
3543	Сэлбэг хэрэгсэл	1,001,000.00	1,301,000.00
356	Мал амьтад	42,810,000.00	27,740,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	17,375,000.00	81,864,000.00
363	Тэжээлийн нөөц	17,375,000.00	81,864,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,040,127,002.49	2,006,901,101.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,040,127,002.49	2,006,901,101.53
392	Биет хөрөнгө	2,019,073,502.09	1,985,970,101.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	719,201,553.13	888,605,427.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-219,382,258.38	-282,402,658.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	357,006,610.00	382,591,325.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-240,413,885.16	-245,457,112.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,231,541.49	173,662,412.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-125,569,891.27	-103,570,732.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	77,455,407.77	99,899,670.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,251,001.98	-33,717,705.09
39209	Зам, гүүрийн байгууламж	2,347,244,764.50	2,435,459,764.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,059,522,338.01	-1,329,173,289.62
39217	Ном	73,000.00	73,000.00
393	Биет бус хөрөнгө	21,053,500.40	20,930,999.98
39301	Програм хангамж	3,250,000.00	780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,087,499.60	-740,000.02
39303	Бусад биет бус хөрөнгө	20,891,000.00	20,891,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,119,805,002.49	2,163,019,755.52
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,119,805,002.49	2,163,019,755.52
51	Засгийн газрын хувь оролцоо	2,119,805,002.49	2,163,019,755.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	496,878,327.97	496,878,327.97
51101	Өмч: - төрийн	496,878,327.97	496,878,327.97
512	Хуримтлагдсан үр дүн	1,324,227,047.25	1,367,441,800.28
5121	Өмнөх үеийн үр дүн	1,324,227,047.25	1,324,227,047.25
5122	Тайлант үеийн үр дүн		43,214,753.03
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,699,627.27	298,699,627.27
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,119,805,002.49	2,163,019,755.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,232,385,204.00	1,789,070,547.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,857,574.00	470,386,948.21
120	Нийтлэг татварын бус орлого	308,857,574.00	470,386,948.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	314,600.00	952,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	314,600.00	952,700.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	294,782,974.00	340,502,900.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,760,000.00	128,931,347.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	923,527,630.00	1,318,683,599.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115,246,430.00	79,446,499.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,244,800.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,036,480.00	3,320,499.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,965,150.00	70,076,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	809,526,000.00	1,239,237,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	808,281,200.00	1,239,237,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,271,019,837.31	1,745,855,794.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,271,019,837.31	1,745,855,794.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,249,870,939.71	1,596,400,872.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,182,390.00	638,545,626.00
210101	Үндсэн цалин	301,793,179.00	389,637,840.00
210102	Нэмэгдэл	100,163,465.00	216,894,363.00
210104	Урамшуулал	34,014,286.00	32,013,423.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,211,460.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,193,810.00	79,852,207.99
210201	Тэтгэврийн даатгал	37,463,161.16	55,080,964.58
210202	Тэтгэмжийн даатгал	4,422,286.79	6,302,121.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,955,241.17	4,583,033.88
210204	Ажилгүйдлийн даатгал	850,281.66	1,320,786.74
210205	Эрүүл мэндийн даатгал	8,502,839.22	12,565,301.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,706,776.20	42,951,122.07
210301	Гэрэл, цахилгаан	10,286,940.35	10,788,822.07
210302	Түлш, халаалт	22,306,535.85	32,029,000.00
210303	Цэвэр, бохир ус	113,300.00	133,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	84,431,719.67	130,759,284.08
210401	Бичиг хэрэг	8,283,300.00	11,414,288.00
210402	Тээвэр, шатахуун	30,794,248.07	83,740,020.28
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,629,423.20	7,798,046.80
210404	Ном, хэвлэл	480,000.00	1,870,012.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,165,748.40	19,329,017.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	6,607,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	22,279,000.00	0.00
2105	Нормативт зардал	1,720,000.00	2,000,000.00

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,720,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,817,000.00	12,522,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	370,000.00	0.00
210602	Тавилга	0.00	60,000.00
210604	Урсгал засвар	14,447,000.00	12,462,300.00
2107	Томилолт, зочны зардал	8,521,070.00	9,000,000.00
210702	Дотоод албан томилолт	8,521,070.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,732,963.93	57,093,730.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,743,576.93	55,698,204.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	421,140.00	1,182,042.04
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,500.00	98,584.04
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	69,900.00
210807	Газрын төлбөр	36,747.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	541,565,209.91	623,676,601.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	129,992,126.60	189,283,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	411,573,083.31	434,392,701.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,148,897.60	149,454,922.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,750,000.00	98,989,632.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	40,400,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	51,039,432.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,750,000.00	7,550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,398,897.60	50,463,290.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,398,897.60	50,463,290.07
213503	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-38,634,633.31	43,214,753.03
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-38,634,633.31	43,214,753.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	923,842,230.00	1,325,106,299.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	314,600.00	952,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	314,600.00	952,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	314,600.00	952,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	314,600.00	952,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	923,527,630.00	1,320,169,799.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,001,630.00	84,916,499.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,244,800.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,036,480.00	3,320,499.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,965,150.00	75,546,000.00

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	809,526,000.00	1,239,237,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	808,281,200.00	1,239,237,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	845,656,430.00	1,264,442,399.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	845,656,430.00	1,264,442,399.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	824,757,532.40	1,114,037,476.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,588,700.00	639,008,005.00
210101	Үндсэн цалин	307,047,650.47	390,100,219.00
210102	Нэмэгдэл	96,794,974.35	216,894,363.00
210104	Урамшуулал	32,707,281.18	32,013,423.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,038,794.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,787,500.00	78,722,241.98
210201	Тэтгэврийн даатгал	38,055,500.00	53,950,998.57
210202	Тэтгэмжийн даатгал	4,183,000.00	6,302,121.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,346,400.00	4,583,033.88
210204	Ажилгүйдлийн даатгал	836,600.00	1,320,786.74
210205	Эрүүл мэндийн даатгал	8,366,000.00	12,565,301.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,235,800.00	42,661,122.07
210301	Гэрэл, цахилгаан	15,000,000.00	10,498,822.07
210302	Түлш, халаалт	20,000,000.00	32,029,000.00
210303	Цэвэр, бохир ус	235,800.00	133,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,287,969.40	77,760,524.80
210401	Бичиг хэрэг	7,225,000.00	9,361,300.00
210402	Тээвэр, шатахуун	20,544,800.00	27,048,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,599,969.40	7,597,546.80
210404	Ном, хэвлэл	600,000.00	2,250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	22,818,200.00	24,896,028.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	6,607,000.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	2,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,540,000.00	14,073,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,350,000.00	463,800.00
210602	Тавилга	0.00	60,000.00
210604	Урсгал засвар	12,190,000.00	13,550,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,207,000.00	9,000,000.00
210702	Дотоод албан томилолт	7,207,000.00	9,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,522,963.00	119,177,083.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,326,576.00	117,501,457.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	496,140.00	1,182,042.04
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,500.00	98,584.04
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	350,000.00
210807	Газрын төлбөр	36,747.00	45,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,087,600.00	131,634,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,087,600.00	131,634,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,898,897.60	150,404,922.07

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	4,500,000.00	99,939,632.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	40,400,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	51,039,432.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500,000.00	8,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,398,897.60	50,465,290.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,519,897.60	50,463,290.07
213503	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	78,185,800.00	60,663,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	78,185,800.00	60,663,900.00
	Дотоод эх үүсвэрээр	78,185,800.00	60,663,900.00
221001	Их засвар	49,800,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,385,800.00	60,663,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-78,185,800.00	-60,663,900.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,324,227,047.25	2,119,805,002.49
2	Тайлант үеийн үр дүн			-104,086,620.97	-104,086,620.97
3	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,324,227,047.25	2,119,805,002.49
4	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,324,227,047.25	2,119,805,002.49
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	43,214,753.03	43,214,753.03
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,367,441,800.28	2,163,019,755.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,235,423,300.00	1,189,726,509.93	45,696,790.07	95.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,423,300.00	1,189,726,509.93	45,696,790.07	95.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,134,701,100.00	1,189,786,877.93	44,914,222.07	95.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	653,658,300.00	639,008,005.00	14,650,295.00	97.76
210101	Үндсэн цалин	405,096,700.00	390,100,219.00	14,996,481.00	96.3
210102	Нэмэгдэл	236,626,500.00	216,894,363.00	19,732,137.00	91.66

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	11,935,100.00	32,013,423.00	-20,078,323.00	268.2 3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,707,800.00	78,722,241.98	2,985,558.02	96.35
210201	Тэтгэврийн даатгал	55,561,500.00	53,950,998.57	1,610,501.43	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	6,536,500.00	6,302,121.75	234,378.25	96.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,229,300.00	4,583,033.88	646,266.12	87.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,307,300.00	1,320,786.74	-13,486.74	101.0 3
210205	Эрүүл мэндийн даатгал	13,073,200.00	12,565,301.04	507,898.96	96.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,235,800.00	42,661,122.07	2,574,677.93	94.31
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000.00	10,498,822.07	2,501,177.93	80.76
210302	Түлш, халаалт	32,000,000.00	32,029,000.00	-29,000.00	100.0 9
210303	Цэвэр, бохир ус	235,800.00	133,300.00	102,500.00	56.53
2104	Хангамж, бараа материалын зардал	76,437,500.00	76,430,524.80	6,975.20	99.99
210401	Бичиг хэрэг	10,081,300.00	10,081,300.00	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	24,998,650.00	1,350.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,600,000.00	7,597,546.80	2,453.20	99.97
210404	Ном, хэвлэл	2,250,000.00	2,250,000.00	0.00	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,899,200.00	24,896,028.00	3,172.00	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,607,000.00	6,607,000.00	0.00	100
2105	Нормативт зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,017,700.00	61,017,700.00	0.00	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,467,700.00	27,467,700.00	0.00	100
210602	Тавилга	20,000,000.00	20,000,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	13,550,000.00	13,550,000.00	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	9,000,000.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	9,000,000.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	151,044,000.00	126,356,584.08	24,687,415.92	83.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	149,365,000.00	124,680,958.00	24,684,042.00	83.47
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,184,000.00	1,182,042.04	1,957.96	99.83
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	98,584.04	1,415.96	98.58
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	0.00	100
210807	Газрын төлбөр	45,000.00	45,000.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,600,000.00	54,590,700.00	9,300.00	99.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,600,000.00	54,590,700.00	9,300.00	99.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,722,200.00	99,939,632.00	782,568.00	99.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,722,200.00	99,939,632.00	782,568.00	99.22
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,400,200.00	40,400,200.00	0.00	100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	51,822,000.00	51,039,432.00	782,568.00	98.49
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,500,000.00	8,500,000.00	0.00	100
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	60,663,900.00	-60,663,900.00	
	Дотоод эх үүсвэрээр	0.00	60,663,900.00	-60,663,900.00	

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,235,423,300.00	1,189,726,509.93	45,696,790.07	95.98
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,235,253,300.00	1,188,773,809.93	46,479,490.07	
132001	Орон нутгийн төсвөөс	1,235,253,300.00	1,188,773,809.93	46,479,490.07	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,000.00	952,700.00	-782,700.00	0.57
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,000.00	952,700.00	-782,700.00	560.41
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	1	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО		29	27	
6	Удирдах ажилтан		3	3	
7	Гүйцэтгэх ажилтан		14	12	
8	Үйлчлэх ажилтан		9	9	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,914,499.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,914,499.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,914,499.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,050,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,050,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,320,499.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,320,499.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,544,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,544,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84,914,499.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,914,499.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,320,499.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,544,000.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 73,847.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

Тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан 73,847.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг бараа материалын дэлгэрэнгүй тайланд тусгалгүй орхигдуулсныг аудитын явцад залрууллаа.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 14.4.2, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 9,599.5 мянган төгрөгийн зөрчил² илэрч 4,391.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 5,208.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй материаллаг алдаа зөрчил нь 9,599.5 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 13,898.5 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тайлант онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 6 албан хаагчид олгоходоо ХХОАТ-ыг суутгалгүй нийт 4,391,000.0 төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Тайлант онд Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/28 дугаар захирамжаар засаг даргын орлогч, Азарга, Хануй, Донгой, Бэлхи, Баянгол багийн засаг дарга нарт нийт 5,208,500 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 10.3-д "Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" гэсний 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.1.6 "Сахилга баттай байх", 4.1.9 "Хариуцлагатай байх" 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мян.төг/			
			Үүнээс		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөө орон нутагт суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллаас 6 албан хаагчид нийт 4,391.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	4,391.0	1	4,391.0		
Улс төрийн албан тушаалтнуудад 5,208.5 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн сангаас олгож, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.	1	5,208.5			1	5,208.5
Нийт дүн	2	9,599.5	1	4,391.0	1	5,208.5